



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 338

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын виз олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ᠶᠡᠨᠡᠭᠡ ᠣᠡᠨᠡᠭᠡ Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын виз хүссэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-д виз, визийн зөвшөөрөл олгох, визийн ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгоход Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг мөрдөхөд энэ журам үйлчлэхгүй.

Хоёр. Визийн зөвшөөрөл олгох

2.1. Дипломат, албан зэргийн бүх төрлийн визийн болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7-д заасан ангиллын 30 хүртэлх хоногийн орох зориулалтын нэг болон хоёр удаагийн энгийн зэргийн визийн зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад визийн зөвшөөрлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

2.3. Визийн зөвшөөрөл нь тухайн визийн зөвшөөрөл олгогдсон өдрөөс 183 хоногийн дотор хүчинтэй байна.

2.4. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь визийн зөвшөөрөл олгосон тохиолдолд энэ тухай Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт дахь албанд мэдэгдэнэ.

2.5. Уригч нь хилийн боомт дээр гадаадын иргэнд виз олгуулах хүсэлтээ тухайн гадаадын иргэнийг Монгол Улсад ирэхээс 14 хоногийн өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.6. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн нь албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд зохих ангиллын визийн зөвшөөрөл авна.

2.7. Визийн зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдүүлгийн хуудас бөглөн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.7.1. уригчийн хүсэлт;

2.7.2. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичгийн хуулбар;

2.7.3. хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулахаар ирэх гадаадын иргэнд эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас олгосон зөвшөөрөл, суралцахаар ирэх гадаадын иргэнд тухайн байгууллага /гадаадын иргэний суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх/-ын тодорхойлолт;

2.7.4. байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай бол гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт;

2.7.5. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээний эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

2.8. Шаардлагатай тохиолдолд визийн зөвшөөрөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын 2.7-д зааснаас гадна дараахь нэмэлт бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.8.1. гадаадын хөрөнгө оруулагч визийн зөвшөөрөл хүсэхдээ хөрөнгө оруулсан талаархи нотолгоо, татварын байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулах бол түүний хуулбар;

2.8.2. түр ирэгчид олон удаагийн визийн мөн зөвшөөрөл хүсэхдээ уригч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, татварын байгууллагын тодорхойлолт, тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулах бол түүний хуулбар;

2.8.3. түр ирэгчид нэг болон хоёр удаагийн визийн зөвшөөрөл хүсэхдээ тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулах бол уг зөвшөөрлийн хуулбар.

Гурав. Виз, визийн зориулалт, төрөл, хугацаа

- 3.1. Визийн хуудсанд дараахь мэдээллийг тэмдэглэнэ:
 - 3.1.1. гадаадын иргэний зураг (photo);
 - 3.1.2. визийн хүчинтэй хугацаа (enter before);
 - 3.1.3. байх хугацаа (duration of stay);
 - 3.1.4. визийн зэрэг (level);
 - 3.1.5. визийн зориулалт (visa type);
 - 3.1.6. визийн ангилал (classification);
 - 3.1.7. визийн төрөл (entries);
 - 3.1.8. гадаадын иргэний овог, нэр (full name);
 - 3.1.9. иргэний харьяалал (citizenship);
 - 3.1.10. гадаадын иргэний паспортын дугаар (passport number);
 - 3.1.11. олгосон огноо (date of issue);
 - 3.1.12. олгосон газар (issued at);
 - 3.1.13. тусгай тэмдэглэл (remarks).
- 3.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.5-д заасан зориулалтын визийг дараахь гадаадын иргэнд олгоно:
 - 3.2.1. түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд “орох”;
 - 3.2.2. албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсаас гараад буцаж ирэх бол “гарах-орох”;
 - 3.2.3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнд “дамжин өнгөрөх”.
- 3.3. Визийн зориулалтыг визийн хуудсан дээр дараахь байдлаар тэмдэглэнэ:
 - 3.3.1. “орох” визийг “Entry”;
 - 3.3.2. “гарах-орох” визийг “Re entry”;
 - 3.3.3. “дамжин өнгөрөх” визийг “Transit”.
- 3.4. “Орох”, “гарах-орох”, “дамжин өнгөрөх” зориулалтын виз нь нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байна.
- 3.5. Визийн төрлийг визийн хуудсан дээр дараахь байдлаар тэмдэглэнэ:
 - 3.5.1. нэг удаагийн визийг “Single”;
 - 3.5.2. хоёр удаагийн визийг “Double”;
 - 3.5.3. олон удаагийн визийг “Multiple”.
- 3.6. Визийн хүчинтэй хугацаа гэдэг нь орох, дамжин өнгөрөх бүх төрлийн визийн хувьд виз олгосон өдрөөс Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэлх хугацаа бөгөөд визийн хуудасны “enter before” хэсэгт тэмдэглэнэ.
- 3.7. Нэг болон хоёр удаагийн “гарах-орох” визийн хүчинтэй хугацаа нь гадаадын иргэний Монгол Улсаас гараад буцаж ирэх хугацаа бөгөөд гадаад улсад байх хугацааг мөн тодорхойлно. “Гарах-орох” визийн хүчинтэй хугацааг визийн хуудасны “enter before” хэсэгт тэмдэглэнэ.
- 3.8. Виз нь дараахь хугацаанд хүчинтэй байна:
 - 3.8.1. нэг болон хоёр удаагийн “орох” виз 90 хоног;
 - 3.8.2. нэг болон хоёр удаагийн “гарах-орох” виз 180 хүртэл хоног;
 - 3.8.3. нэг болон хоёр удаагийн “дамжин өнгөрөх” виз 90 хоног;
 - 3.8.4. түр ирэгчид олгох олон удаагийн визийн хүчинтэй хугацаа нь 183 буюу 365 хоног.
- 3.9. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгох “гарах-орох” бүх төрлийн визийн хүчинтэй хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хэтрэхгүй байна.
- 3.10. Визийн “байх хугацаа” гэдэг нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр орж ирснээс хойш тус улсад байх хугацаа бөгөөд визийн хуудасны “Duration of stay” хэсэгт тэмдэглэнэ.
- 3.11. Визэнд бичигдсэн “байх хугацаа” нь дараахь хугацаатай байна:
 - 3.11.1. нэг болон хоёр удаагийн орох виз 90 хүртэл хоног;
 - 3.11.2. түр ирэгчид олгох олон удаагийн виз 30 хоног;

3.11.3. нэг болон хоёр удаагийн “дамжин өнгөрөх” виз 10 хүртэл хоног.

3.12. Албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх гадаадын иргэний “орох” визэнд энэхүү журмын 3.10-т заасан хугацааг заахгүй.

Дөрөв. Виз олгох

4.1. Гадаадын иргэн нь ирсэн зорилгодоо нийцсэн ангилал бүхий виз авсан байна.

4.2. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн нь гэрээнд зааснаас илүү хугацаагаар ирэх бол зохих ангиллын визийг урьдчилан авна.

4.3. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаанд визгүй зорчих гадаадын иргэн нь тухайн гэрээнд өөрөөр заагаагүй бол зөвхөн аялах, зочлох зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрэх тохиолдолд визгүй зорчино.

4.4. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тодорхой хугацаанд тус улсад визгүй зорчих гадаадын иргэн тухайн гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсаас гараад буцаж ирэх тохиолдолд зохих журмын дагуу “гарах-орох” виз авна.

4.5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 17.2.2, 17.2.3-т заасны дагуу Монгол Улсын хилийн боомт дээр гадаадын иргэнд виз олгоно.

4.6. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул байхгүй гадаад улсаас ирж байгаа гадаадын иргэнд шаардлагатай тохиолдолд олон улсын хилийн боомт дээр “орох” виз олгож болно.

4.7. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасны дагуу Монгол Улсад албан хэргээр оршин суух болон түр ирэх гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага виз, визийн зөвшөөрөл олгож болно.

4.8. Шаардлагатай тохиолдолд хилийн боомт дээр Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд уригч байгууллага, иргэний албан бичиг, өргөдлийг үндэслэн мэдүүлгийн хуудас бөглүүлэн “гарах-орох” виз олгоно.

4.9. Хилийн боомт дээр гадаадын иргэнд “дамжин өнгөрөх” виз олгохдоо тухайн гадаадын иргэний очих улсын виз болон тийзгийг үндэслэнэ.

4.10. Виз хүсэгчтэй хийх ярилцлагын сэдвийг виз олгогч өөрөө тогтоох бөгөөд ярилцлага хийсний үндсэн дээр виз олгохоос татгалзах эрхтэй.

4.11. Виз хүсэгч гадаадын иргэн виз мэдүүлэхээс өмнө визийн хураамжийг урьдчилан төлсөн байна. Виз олгогч виз олгохоос татгалзсан тохиолдолд хураамжийг буцаан олгохгүй.

4.12. Виз олгогч нь виз хүсэгчийн паспорт буюу паспортыг орлох баримт бичгийн хуурамч болон гэмтэлтэй эсэхийг шалган, ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөн виз олгох үндэслэлтэй гэж үзвэл мэдүүлгийн хуудас бөглүүлж, виз олгоно.

4.13. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар болон өргөмжит консул нь Монгол Улсыг хавсран суугаа болон гадаад улсын бусад дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөний ноот бичгийг үндэслэн гадаадын иргэнд виз олгож болно.

4.14. Визийг гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт, харьяалалгүй хүнд байнга оршин суугаа улсаас нь олгосон гадаадад зорчих үнэмлэхэд Монгол Улс хүлээн зөвшөөрөөгүй нутаг дэвсгэрийн харьяат нарт Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.3-т заасны дагуу тэдний паспорттай адилтгах баримт бичгийн хуулбарт буюу виз олгогч өөрөө бэлтгэсэн хавсралт хуудсанд нааж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулна.

4.15. Энэ журмын 4.14-т заасан хавсралт нь паспортын дэлгэмэл хуудасны хэмжээтэй байна. Хавсралтын нэг талд нь тухайн хүний эзэмшиж байгаа баримт бичгийн хуулбарыг хийж, нөгөө талд нь олгосон визийг наана.

4.16. Виз бүхий паспорт буюу паспортыг орлох баримт бичгийг үргэдүүлсэн, солиулсан гадаадын иргэнд визийн хугацаа нь хэтрээгүй тохиолдолд уг визийг дахин олгож болно.

4.17. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан виз олгох эрх бүхий байгууллага нь Монгол Улсын иргэний 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхдэд “Н” ангиллын 90 хүртэл хоногийн “орох” зориулалтын нэг болон хоёр удаагийн визийг визийн зөвшөөрөлгүйгээр олгож болно.

4.18. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул болон хилийн боомт дээр виз хүсэгч гадаадын иргэн нь мэдүүлгийн хуудас бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.18.1. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт, эсхүл түүнийг орлох хууль ёсны бичиг баримт;

4.18.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан байгууллагаас олгосон визийн зөвшөөрөл, хувийн урилга;

- 4.18.3. 3x4 см хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- 4.18.4. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээний эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.
- 4.19. Энэ журмын 4.18-д зааснаас бусад виз хүсэгч нь мэдүүлгийн хуудас бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:
 - 4.19.1. уригчийн хүсэлт;
 - 4.19.2. уригч нь байгууллага бол тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт;
 - 4.19.3. уригч нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бол тухайн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт;
 - 4.19.4. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээний эх хувийг хуулбар болон орчуулгын хамт;
 - 4.19.5. энэ журмын 4.18.1, 4.18.3-т заасан бичиг баримт.
- 4.20. Шаардлагатай тохиолдолд виз хүсэгч нь энэ журмын 4.18-д зааснаас гадна мөн журмын 2.8-д заасан нэмэлт бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 4.21. Визэнд дараахь албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна:
 - 4.21.1. гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан газрын захирал, дэд захирал;
 - 4.21.2. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, консулын хэлтсийн дарга, консулын албан тушаалтан, өргөмжит консул;
 - 4.21.3. гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, түүний эрх олгосон албан тушаалтан.
- 4.22. Визийн зөвшөөрөл, мэдүүлгийн хуудасны загварыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 4.23. Визийн зэрэг, ангилал, зориулалт, төрөл, хугацааг визийн хуудсан дээр буруу тэмдэглэснээс визийн хуудас хүчингүй болсон тохиолдолд визийн хуудасны үнийг виз үйлдсэн ажилтан төлнө.

Тав. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах,
визийг хүчингүй болгох үндэслэл

- 5.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна дараахь үндэслэлээр виз, визийн зөвшөөрлийг олгохоос татгалзана:
 - 5.1.1. гадаадын иргэн виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхээс өмнө 3 сарын хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан зөрчил гаргаж захиргааны шийтгэл хүлээсэн;
 - 5.1.2. виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхээс өмнө 1 жилийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан зөрчлийг 2 буюу түүнээс дээш удаа гаргасан уригч;
 - 5.1.3. хуурамч бичиг баримт бүрдүүлэн виз мэдүүлсэн;
 - 5.1.4. худал мэдүүлэг өгсөн.
- 5.2. Түр ирэгчид олгох олон удаагийн виз, визийн зөвшөөрлийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох журамд заасан зөрчлийг сүүлийн 3 жилд 2 буюу түүнээс дээш удаа гаргаж байсан гадаадын иргэнд олгохгүй.
- 5.3. Визийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:
 - 5.3.1. визийг хуурамчаар үйлдсэн;
 - 5.3.2. уригч байгууллага, иргэний үндэслэл бүхий хүсэлтээр;
 - 5.3.3. ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;
 - 5.3.4. хууль хяналтын байгууллагын саналыг үндэслэн;
 - 5.3.5. виз буруу бичигдсэн;
 - 5.3.6. албадан гаргаж байгаа бол;
 - 5.3.7. визийн зөвшөөрөлгүй олгосон;
 - 5.3.8. оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон бол.
- 5.4. Визийг хүчингүй болгохдоо визийн хуудас дээр “хүчингүй” буюу “cancelled” гэсэн дардас дарна.

5.5. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан бол виз, визийн зөвшөөрөл хүсэгч 90 хоногийн дараа дахин хүсэлт гаргаж болно.

Зургаа. Визийн хугацааг сунгах, өөрчлөх болон визийн ангиллыг өөрчлөх

6.1. Дипломат, албан зэргийн визийн Монгол Улсад “байх хугацаа”-г сунгуулах хүсэлтийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энгийн зэргийн визийн тус улсад “байх хугацаа”-г сунгуулах хүсэлтийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан шийдвэрлэнэ.

6.2. Визийн хүчинтэй хугацааг сунгахгүй бөгөөд уг хугацаа дууссан бол тухайн визийг үндэслэн шинээр виз олгож болно.

6.3. Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад “байх хугацаа”-г нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

6.4. Түр ирэгч гадаадын иргэний визийн сунгалт хоорондын хугацаа 6 сараас доошгүй байна.

6.5. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан үзээд үндэслэлтэй гэж үзвэл визийн ангиллыг өөрчилж болно.

6.6. Виз олгогч нь гадаадын иргэнд олгох визийн ангилал, төрөл, хугацааг визийн зөвшөөрөлгүй болон алдаатай бичсэн тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэхүү журамд нийцүүлэн өөрчилж болно.

6.7. Гадаадын иргэн Монгол Улсад байх визийн хугацааг сунгуулах хүсэлтээ уг хугацаа дуусахаас ажлын 4 хоногийн өмнө гаргана.

6.8. Визийн хугацааг сунгахдаа бүртгэл хийн “бүртгэв” гэсэн дардас дарна. “Бүртгэв” гэсэн дардсанд гадаадын иргэнийг бүртгэсэн он, сар, өдрийг тэмдэглэж дардасны хажууд бүртгэлийн дугаарыг бичиж тэмдэглэнэ.

6.9. Визийн хугацааг сунгах хоногийг “хасав” дардасны зүүн доод буланд бичнэ. Сунгасан визийн дугаарыг мөн дардсанд бичиж тэмдэглэнэ. “Хасав” дардасны “он, сар, өдөр” гэсэн хэсэгт визийн сунгалтын сүүлийн өдрийг бичиж тэмдэглэнэ.

6.10. Виз олгогч визэнд засвар хийж өөрчилсөн тохиолдолд өөрчлөлт дээр тэмдэг дарж баталгаажуулна.

Долоо. Бусад зүйл

7.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 42.1-д заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулсан гадаадын иргэний паспортад нь гарах хугацааг заасан “хасалт” хийнэ.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хасалт нь захиргааны шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 10 хүртэл хоногийн хугацаатай байна. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж Монгол Улсаас гарах үүрэгтэй.

7.3. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул нь виз олгосон баримтыг өөрийн байгууллагад 1 жил хадгалсны дараа устгана. Тухайн жилд олгосон дипломат, албан зэргийн визийн мэдээллийг цахим хэлбэрээр нэгтгэн гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энгийн зэргийн визийн мэдээллийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа оны эхний сард багтаан тус тус хүргүүлнэ.

7.4. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан визийн ангилал өөрчлөх, бүртгэх, хасалт хийх дардасны загварыг, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөн хуулийн 17.2.1-д заасан визийн ангилал өөрчлөх, бүртгэх, хасалт хийх дардасны загварыг тус тус баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

7.5. Шаардлагатай тохиолдолд зарим гадаад орны иргэнд виз, визийн зөвшөөрөл олгохдоо хууль хяналтын байгууллагаас санал авч шийдвэрлэнэ.

7.6. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь визийн зөвшөөрлийн мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын хоёр хоногт, визийн мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын гурав хоногт, яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаан гүйцэтгэнэ.

7.7. Виз, визийн зөвшөөрөл хүсэгчийн паспорт, түүнийг орлох баримт бичгийн хүчинтэй хугацаа түр ирэгчийн хувьд 6 сараас доошгүй, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний хувьд 1 жилээс доошгүй байна.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 339

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 79 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ᠶᠡᠭᠡᠨᠡᠭᠡ ᠣᠡᠨᠠᠭᠢ Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.НЯМДОРЖ

**ГАДААДЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСААС АЛБАДАН ГАРГАХ
БОЛОН МОНГОЛ УЛСАД ДАХИН ОРУУЛАХГҮЙ БАЙХ
ХУГАЦАА ТОГТООХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-д заасан үндэслэлээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-ийг Монгол Улсаас албадан гаргах болон албадан гаргах гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтооход холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Албадан гаргах гадаадын иргэн нь Монгол Улсаас гарч яваагүй шалтгаан, нөхцөлөө тайлбарлах эрхтэй.

Хоёр. Албадан гаргах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх

2.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-д заасан зөрчил илрүүлсэн хяналтын улсын байцаагч нь тухайн гадаадын иргэний талаар хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулна.

2.2. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь энэ журмын 2.1-д заасан дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэр гаргана. Албадан гаргах шийдвэрт тухайн иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг заана.

2.3. Гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэр гарсан тохиолдолд хяналтын улсын байцаагч дараахь арга хэмжээ авна:

2.3.1. Монгол Улсаас албадан гаргах болсон тухай шийдвэрийг тухайн гадаадын иргэнд танилцуулан холбогдох зардлыг өөрөө хариуцахыг мэдэгдэх;

2.3.2. албадан гаргах гадаадын иргэний оршин суух хаяг тодорхойгүй буюу бүртгүүлсэн хаяг дээрээ байхгүй, эсхүл тухайн гадаадын иргэн албадан гаргах ажиллагаанд саад учруулсан тохиолдолд цагдаагийн байгууллагын тусламжтайгаар түүнийг олж тогтоох, шаардлагатай гэж үзвэл түүнийг албадан гаргах хүртэл түр саатуулах;

2.3.3. албадан гаргах гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох баримт бичгийг Монгол Улсаас гарах хүртэл хугацаанд түр хадгалах, баримт бичиггүй тохиолдолд баримт бичиг олгуулах асуудлыг тухайн этгээдийг харьяалах орны дипломат төлөөлөгчийн газарт гавьж шийдвэрлүүлэх, хэрэв тухайн этгээдийн харьяалах орны дипломат төлөөлөгчийн газар тус улсад байхгүй тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэх;

2.3.4. гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг гарснаас нь хойш 24 цагийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хил хамгаалах байгууллагад хүргүүлэх;

2.3.5. албадан гаргах гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох баримт бичигт Монгол Улсаас албадан гаргасан тухай дардас дарж, уг иргэний гарын хурууны хээ, гэрэл зураг бүхий мэдээллийг тухайн гадаадын иргэний хувийн хэрэг болон гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд нэн даруй оруулах;

2.3.6. албадан гаргахтай холбоотой зардлыг тухайн гадаадын иргэнээс гаргуулах, түүний зорчих олон улсын тээврийн хэрэгслийн тийз захиалах, худалдан авах ажлыг зохион байгуулах;

2.3.7. албадан гаргах гадаадын иргэн нь зардлаа өөрөө хариуцах санхүүгийн боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд албадан гаргахад шаардагдах зардлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албадан гаргах ажиллагааны зардлаас гаргуулах;

2.3.8. шаардлагатай тохиолдолд албадан гаргах гадаадын иргэнийг түүнийг харьяалах, эсхүл холбогдох улсад хуяглан хүргэх;

2.3.9. гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлсэн тухай дүнг уг шийдвэрийг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулах.

2.4. Гадаадын иргэнийг албадан гаргах тухай шийдвэрийг хүлээн авсан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь үүргийг хүлээнэ:

2.4.1. гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хүлээн авмагц энэ талаар тухайн гадаадын иргэнийг харьяалах орны дипломат төлөөлөгчийн газарт албан ёсоор мэдэгдэж, шаардлагатай бол тайлбар өгөх;

2.4.2. гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрт заасан Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаанд уг гадаадын иргэнд виз олгохгүй байхыг тус улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэдэгдэх.

2.5. Гадаадын иргэнийг албадан гаргах тухай шийдвэрийг хүлээн авсан цагдаагийн байгууллага дараахь үүргийг хүлээнэ:

2.5.1. шаардлагатай тохиолдолд албадан гаргах гадаадын иргэнийг хилийн боомт хүртэл хуяглан

хүргэх ажлыг зохион байгуулах;

2.5.2. гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлэх явцад нисэх онгоцны болон галт тэрэгний буудалд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн хүч хэрэгслээр хамгаалалт зохион байгуулах, автомашинаар хүргэх үед зам тээврийн осол гарахаас сэргийлж, шаардлагатай тохилдолд хамгаалалт хийх.

2.6. Гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хүлээн авсан хил хамгаалах байгууллага дараахь үүргийг хүлээнэ:

2.6.1. албадан гаргаж байгаа гадаадын иргэний талаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн шалган нэвтрүүлэх байгууллагад урьдчилан мэдэгдэж, хамтран ажиллах;

2.6.2. албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах үед хилээр нэн даруй нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах;

2.6.3. албадан гаргах гадаадын иргэнийг шаардлагатай үед хилийн боомтод байрлуулах, хамгаалах, хоол, хүнсээр хангах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авах;

2.6.4. албадан гаргах шийдвэрт заасан Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаанд гадаадын иргэнийг тус улсын хилээр нэвтрүүлэхгүй байх.

Гурав. Албадан гаргах гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч бичиг баримтаар нэвтэрсэн нь нотлогдсон бол тухайн гадаадын иргэнийг албадан гаргасан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.2. Гадаадын иргэнийг Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан боловч тус улсаас гарч явахаас зайлсхийсэн бол албадан гаргасан өдрөөс эхлэн дор дурдсан хугацаагаар Монгол Улсад дахин оруулахгүй:

3.2.1. оршин суух зөвшөөрлийн хугацааг 2 сараас 6 сар хүртэл хугацаагаар хэтрүүлсэн бол 1 жил;

3.2.2. оршин суух зөвшөөрлийн хугацааг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хэтрүүлсэн бол 2 жил;

3.2.3. оршин суух зөвшөөрлийн хугацааг 1 жилээс дээш хугацаагаар хэтрүүлсэн бол 3 жил.

3.3. Түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг нэг жилд 2 буюу түүнээс дээш удаа зөрчиж Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан захиргааны шийтгэл хүлээсэн бол 1 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.4. Мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан гадаадын иргэнийг 10 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.5. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 11.3-т заасан үндэслэл бий болсон буюу эрүүл мэндийн байгууллага сэтгэцийн өвчтэй болохыг нь тогтоосон гадаадын иргэнийг 10 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.6. Хуурамч бичиг баримт ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон гадаадын иргэнийг 7 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.7. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон гадаадын иргэнийг 3 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.8. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй гадаадын иргэнийг 1 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.9. Нийгмийн хэв журмыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны шийтгэл хүлээсэн гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн бол түүнийг 1 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн бол тухайн гадаадын иргэнийг 10 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.11. Шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээний дагуу түүнийг харьяалах оронд нь шилжүүлэхээр болсон бол тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялтайд тооцох хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.

3.12. Түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн бол албадан гаргасан өдрөөс эхлэн дор дурдсан хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй:

3.12.1. визийн хугацааг 2 сараас 6 сар хүртэл хугацаагаар хэтрүүлсэн бол 1 жил;

3.12.2. визийн хугацааг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хэтрүүлсэн бол 2 жил;

3.12.3. визийн хугацааг 1 жилээс дээш хугацаагаар хэтрүүлсэн бол 3 жил.

3.13. Гадаадын иргэнийг шүүх хугацаанаас өмнө ялгүйд тооцсон тохиолдолд түүнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох, дахин оруулахгүй байх хугацааг богиносгох эсэх асуудлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хянан шийдвэрлэнэ.

Дөрөв. Албадан гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дуусах, Монгол Улсад дахин нэвтрэх

4.1. Албадан гаргасан гадаадын иргэний дахин Монгол Улсад нэвтрэх эрх нь уг иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан шийдвэрт заасан тус улсад дахин оруулахгүй байх хугацаа дууссан өдрөөс эхлэн сэргэнэ.

4.2. Энэ журмын 3.2.3, 3.4-3.7, 3.9, 3.10, 3.12.3-т заасан үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дууссан тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Монгол Улсад нэвтрэх эрхийг сэргээх эсэх асуудлыг хянан үзээд уг хугацааг албадан гаргах шийдвэрт зааснаас илүүгүй хугацаагаар сунгаж болно.

4.3. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа дууссан тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Монгол Улсад нэвтрэх эрхийг нь сэргээх эсэх асуудлыг хянан үзээд уг хугацааг албадан гаргах шийдвэрт зааснаас илүүгүй хугацаагаар сунгаж болно.

Тав. Бусад

5.1. Албадан гаргах гадаадын иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг албадан гаргах шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно.

5.2. Монгол Улсаас албадан гаргах дардасны загварыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

5.3. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргасан гадаадын иргэний тухай мэдээллийг сар бүр дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 340

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас
ТОГТООХ нь:

1. “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 168 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ᠶᠢᠭᠠᠳᠤ ᠪᠡᠭᠡᠨᠢᠭᠢ Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.НЯМДОРЖ

**ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ
БОЛОН ТҮҮНИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид “гадаадын иргэн” гэх/-ийг бүртгэх, бүртгэлээс хасах, оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.2. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд энэ журмыг мөрдөхгүй.

Хоёр. Гадаадын иргэнийг бүртгэх

2.1. Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суух болон төрийн байгууллагын урилгаар ирсэн, Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнийг тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор урьж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, буцах үед бүртгэлээс хасуулна.

2.2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т заасны дагуу Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

2.3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.1-д заасан хувийн хэргээр оршин суугч нь оршин суух зөвшөөрлийн хугацаанд дахин бүртгүүлэхгүй.

2.4. Энэ журмын 2.1-д зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.

2.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг бүртгэхдээ уригч иргэний өргөдөл, аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг /уригчгүй гадаадын иргэн өөрөө бүртгүүлэх бол өргөдөл/, тухайн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг (цаашид “паспорт” гэх), түүний хуулбар, 3x4 см хэмжээний гэрэл зургийг зохих мэдүүлгийн хуудасны хамт хүлээн авч бүртгэнэ.

2.6. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэний паспортад бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр бүхий “бүртгэв” гэсэн дардас дарж, тухайн гадаадын иргэний болон уригчийн талаархи мэдээллийг мэдээллийн санд оруулан мэдүүлгийн хуудсанд тэмдэглэл хийнэ.

2.7. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт болон орон нутаг дахь алба нь хил орчмын нутагт зорчих үнэмлэхээр ирсэн гадаадын иргэн зорчих үнэмлэхэд заасан хилийн боомтоор нэвтэрч, зөвшөөрсөн хил орчмын нутагт зорчиж, хугацаандаа гарч байгаа эсэхийг бүртгэж, хяналт тавина.

Гурав. Албан хэргээр Монгол Улсад оршин суух

3.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д заасны дагуу албан хэргээр оршин суух гадаадын иргэнд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус улсад оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг сунгана.

3.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасны дагуу албан хэргээр оршин суух гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

3.3. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага албан хэргээр оршин суух зөвшөөрлийг 1 жил хүртэл хугацаагаар олгож, сунгана.

3.4. Албан хэргээр оршин суух гадаадын иргэн зохих мэдүүлгийн хуудас бөглөхөөс гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.4.1. энэ журмын 7.1-д заасан зорилгоор оршин суух бол хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллагын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл;

3.4.2. уригч төрийн байгууллагын оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг;

3.4.3. оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн);

3.4.4. 3x4 см хэмжээний 2 хувь гэрэл зураг;

3.4.5. паспорт, түүний хуулбар;

3.4.6. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох хууль ёсны бичиг баримтын эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

Дөрөв. Хувийн хэргээр Монгол Улсад оршин суух

4.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.2-т заасны дагуу хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллага мөн хуулийн 27.4-т заасан гадаадын иргэдийн тоонд багтаан оршин суух зөвшөөрөл олгоно.

4.2. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон мэдүүлгийн хуудсыг бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.2.1. тухайн гадаадын иргэнийг уригч байгууллагын оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг (хувь хүн бол өргөдөл);

4.2.2. оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн);

4.2.3. 3x4 см хэмжээний гэрэл зураг 2 ширхэг;

4.2.4. паспорт, түүний хуулбар;

4.2.5. гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох баримт бичгийн эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

4.3. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрлийн хэлбэрээс хамааран энэ журмын 4.2-т зааснаас гадна нэмэлт материалыг бүрдүүлнэ.

4.4. Энэ журмын 5.1.1, 5.1.2, 6.1, 10.1.1, 10.1.2-т заасан нэг жилээс дээш хугацаагаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага регистрийн дугаар олгож, хувийн хэрэг хөтлөнө.

4.5. Энэ журмын 5.1.3, 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө, бусад хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн мөн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

4.6. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу авсан энэ журмын 5.1.1, 6.1-д заасан гадаадын иргэн 365 хоногийн дараа, мөн журмын 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэн 183 хоногийн дараа дахин тус улсад хувийн хэргээр оршин суух хүсэлт гаргаж болно.

4.7. Энэ журмын 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах болон зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ болон байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт тухай бүр авчирна.

4.8. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл хүссэн бичиг баримтыг эх хувиар нь шаардаж болно.

4.9. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шаардсан тохиолдолд хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн оршин суух хүсэлтээ өөрийн биеэр мэдүүлнэ.

4.10. Гадаадын иргэний эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.9-д заасан тохиолдолд хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэнтэй ярилцлага хийнэ.

4.11. Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг дараахь хугацаагаар олгоно:

4.11.1. гадаадын иргэн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулах бол уг тусгай зөвшөөрлийн хугацаанаас илүүгүй;

4.11.2. энэ журмын 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол тухайн уригч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаанаас илүүгүй.

Тав. Гэр бүлийн шалтгаанаар Монгол Улсад оршин суух

5.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь гадаадын иргэнд гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл олгож, зөвшөөрлийн хугацааг сунгана:

5.1.1. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн;

5.1.2. Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд;

5.1.3. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн болон хувийн бусад зорилгоор оршин суух, гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд;

5.1.4. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч, мэргэжил дээшлүүлэгч гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд.

5.2. Энэ журмын 5.1.1, 5.1.3-т заасан гадаадын иргэн нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл авахдаа мөн журмын 4.2-т зааснаас гадна дараахь нэмэлт бичиг баримтыг бүрдүүлнэ:

5.2.1. Монгол Улсын болон гадаадын иргэний 3 үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг эх, өвөг эцэг, эмэг эхийн);

5.2.2. гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллага /хэрэв хүсэлт гаргагч нь тус улсад оршин сууж байгаа бол цагдаагийн байгууллага/-ын тодорхойлолт;

5.2.3. дархлалын олдмол хомсдолын өвчний шинжилгээний бичиг;

5.2.4. амьжиргааны эх үүсвэрийн талаархи өөрийн гаргасан нотолгоо.

5.3. Энэ журмын 5.1.1, 5.1.3-т заасан гадаадын иргэн нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа өргөдөл болон оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн), гэрлэлтийн гэрчилгээг

бүрдүүлсэн байна.

5.4. Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл авахдаа энэ журмын 4.2-т зааснаас гадна эцэг эх, асран хамгаалагчийн бичиг баримтын эх хувийг хуулбарын хамт бүрдүүлсэн байна.

5.5. Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа өргөдөл болон оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолтыг /хаягийн/ бүрдүүлнэ.

5.6. Энэ журмын 5.1.4-т заасан гадаадын иргэн нь мөн журмын 4.2-т заасан бичиг баримтаас гадна оршин суух зөвшөөрөлтэй хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч, мэргэжил дээшлүүлэгчийн паспортын хуулбарыг бүрдүүлэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гаргана.

5.7. Энэ журмын 5.1.4-т заасан гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрлөө сунгуулахдаа мөн журмын 4.2-т заасан бичиг баримт болон оршин суух зөвшөөрөлтэй хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч, мэргэжил дээшлүүлэгчийн паспортын хуулбарын хамт бүрдүүлсэн байна.

5.8. Энэ журмын 5.1.1, 5.1.3-т заасан гадаадын иргэнд гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль хяналтын байгууллагаас санал авсны үндсэн дээр эхний 3 жилд 1 жил хүртэл хугацаагаар олгож, сунгах бөгөөд цаашид удаан хугацаагаар амьдрах бол 2 жил хүртэл хугацаагаар тухай бүр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгана.

5.9. Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх зорилгоор ирсэн гадаадын иргэн тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авснаас хойш 6 сарын дараа гэр бүлийн гишүүндээ хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй.

5.10. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэний хүүхэд нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Зургаа. Монгол Улсад цагаачлах

6.1. Монгол Улсад цагаачлах зөвшөөрлийг тухайн гадаадын иргэний цагаачлах тухай хүсэлт, боловсрол, мэргэжил, улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж болон холбогдох хууль хяналтын байгууллагын саналыг харгалзан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29.5-д заасан тоонд багтаан эхний 3 жилд 1 жил хүртэл хугацаагаар олгож, сунгана. Цаашид удаан хугацаагаар амьдрах бол 2 жил хүртэл хугацаагаар тухай бүр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгана.

6.2. Монгол Улсад цагаачлан амьдрах хүсэлт гаргагч гадаадын иргэн нь дараахь шалгуурыг хангасан байна:

6.2.1. сарын орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлснээс багагүй байх;

6.2.2. дээд боловсрол буюу Монгол Улсад онц чухал шаардлагатай мэргэжил эзэмшсэн байх;

6.2.3. гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй байх;

6.2.4. Монгол Улсаас албадан гаргаж, тус улсад орох эрхийг нь хязгаарлаж байгаагүй байх.

6.3. Монгол Улсад цагаачлан амьдрах хүсэлт гаргагч гадаадын иргэн нь энэ журмын 4.2-т заасан бичиг баримтаас гадна дараахь нэмэлт материалыг бүрдүүлнэ:

6.3.1. 3 үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг эх, эмэг эх, өвөг эцгийн);

6.3.2. гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллага /хэрэв хүсэлт гаргагч нь тус улсад оршин сууж байгаа бол оршин суугаа сум, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллага/-ын тодорхойлолт;

6.3.3. дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэгийн өвчний шинжилгээний бичиг болон сэтгэцийн өвчтэй эсэх тухай эмнэлгийн байгууллагын магадалгаа;

6.3.4. амьжиргааны эх үүсвэрийн талаархи баталгаа;

6.3.5. 3x4 см хэмжээний 5 хувь гэрэл зураг;

6.3.6. боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын эх хувийг хуулбар болон орчуулгын хамт.

6.4. Цагаач гадаадын иргэнээс Монгол Улсад төрсөн хүүхдэд 1 сарын дотор оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг гаргана.

6.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагаач гадаадын иргэнээс төрсөн хүүхдэд регистрийн дугаар олгож хувийн хэрэг хөтөлнө. Регистрийн дугаарыг төрсний гэрчилгээнд бичнэ.

6.6. Насанд хүрээгүй (16) цагаач иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа эцэг эх, асран хамгаалагчийн оршин суух зөвшөөрлийн хугацаагаар тодорхойлогдоно.

6.7. Монгол Улсад төрсөн цагаач гадаадын иргэний цагаачлах зөвшөөрлийг 3 жил хүртэл хугацаагаар тухай бүр сунгаж болно.

6.8. Цагаач гадаадын иргэнээс төрсөн хүүхдэд оршин суух зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргагч нь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон мэдүүлгийн хуудас бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.8.1. өргөдөл;

6.8.2. хүүхдийн төрсний гэрчилгээ;

6.8.3. эцэг, эхийн оршин суух үнэмлэх;

6.8.4. паспортын хуулбар (харьяалалгүй хүний хувьд гадаадад зорчих үнэмлэх);

6.8.5. хаяг, ам бүлийн талаархи сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

6.8.6. 3x4 см хэмжээний 3 ширхэг гэрэл зураг.

6.9. Цагаач гадаадын иргэн нь жилд 180 хоногоос хэтрэхгүй хугацаагаар гадаад улсад зорчих бөгөөд түүний гадаад

улсад зорчсон тухай тэмдэглэлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр хөтлөн, хяналт тавина.

Долоо. Хөдөлмөр эрхлэхээр Монгол Улсад оршин суух

7.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.2-т заасан бичиг баримт болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон түүний эрх олгосон байгууллагын хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн албан бичгийг үндэслэн гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэхээр оршин суух зөвшөөрлийг 1 жил хүртэл хугацаагаар олгож, сунгана.

7.2. Энэ журмын 5.1.1, 6.1-д заасан гадаадын иргэн нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөр эрхэлнэ.

Найм. Хөрөнгө оруулагчаар Монгол Улсад оршин суух

8.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.2-т заасан бичиг баримт болон гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөл, түрээсэлсэн албан байрны гэрээг үндэслэн гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг 1 жил хүртэл хугацаагаар олгож, сунгана.

8.2. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 8.1-д заасан зөвшөөрлийг олгоно. Зөвшөөрлийн хугацааг сунгахдаа тухайн гадаадын иргэний татвар төлсөн байдал, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянаж үзэн шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа явуулах албаны байр, хөрөнгө оруулалт нь тус улсад бодитойгоор орсон эсэхийг шалгаж шийдвэрлэнэ.

8.3. Хөрөнгө оруулагч нь тодорхой үйл ажиллагаа явуулдаггүй, татвар төлөхөөс зайлсхийсэн бол оршин суух зөвшөөрлийн хугацааг богиносгох буюу хүчингүй болгоно.

Ес. Суралцах зорилгоор Монгол Улсад оршин суух

9.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх 16 насанд хүрсэн гадаадын иргэнд тус улсад оршин суух зөвшөөрлийг 1 жил хүртэл хугацаагаар олгох болон сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахдаа энэ журмын 4.2-т заасан бичиг баримт болон тухайн байгууллага (гадаадын иргэний суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх)-ын тодорхойлолтыг үндэслэнэ.

9.2. Энэ журмын 9.1-д заасан оршин суух зөвшөөрлийг сунгахдаа гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн гадаадын иргэний суралцаж байгаа байдлыг харгалзана.

Арав. Хувийн бусад зорилгоор Монгол Улсад оршин суух

10.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь гадаадын иргэнд дор дурдсан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгоно:

10.1.1. Монгол Улсын иргэнээс төрсөн 16-гаас дээш насны гадаадын иргэнд 5 жил хүртэл хугацаагаар;

10.1.2. Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан, гаргах боломжтой болон харгалзан үзэх бусад шалтгаантай гадаадын иргэнд 1 жил хүртэл хугацаагаар;

10.1.3. хууль хяналтын байгууллагаас гадаадын иргэнд холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл тухайн иргэнийг Монгол Улсад зайлшгүй байх шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагын саналыг үндэслэн 1 жил хүртэл хугацаагаар;

10.1.4. бусад хувийн зорилгоор оршин суух гадаадын иргэнд 1 жил хүртэл хугацаагаар.

10.2. Энэ журмын 10.1.1-д заасан гадаадын иргэн мөн журмын 4.2-т заасан бичиг баримтаас гадна дараахь нэмэлт материалыг бүрдүүлнэ:

10.2.1. 3 үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг эх, өвөг эцэг, эмэг эхийн);

10.2.2. гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллага (хэрэв хүсэлт гаргагч нь тус улсад оршин сууж байгаа бол оршин суугаа сум, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллага)-ын тодорхойлолт.

10.3. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга энэ журмын 10.1.2, 10.1.3, 10.1.4-т заасан гадаадын иргэнд тус улсад оршин суух зөвшөөрөл олгоходоо мөн журмын 4.2-т заасан бичиг баримтаас гадна хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын албан бичгийг үндэслэнэ.

10.4. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 10.1.3-т зааснаас бусад хувийн зорилгоор оршин суух зөвшөөрлийг сунгуулахыг хүссэн гадаадын иргэний өргөдөл, паспорт түүнийг орлох баримт бичгийн хуулбарыг үндэслэн зөвшөөрлийн хугацааг 5 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

Арваннэг. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах
хөрөнгийн эх үүсвэрийн баталгааны төрөл, хэлбэр,
тэдгээрийг мэдүүлэх

11.1. Гадаадын иргэнийг урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэн өөрөө тус улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг (цаашид “баталгаа” гэх) виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга, оршин суух зөвшөөрөл авах үед бичгээр гаргана.

11.2. Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэнээс гаргаж байгаа баталгаанд холбогдох эд хөрөнгө нь банк болон бусад аж ахуйн нэгжид барьцаалагдаагүй байна.

11.3. Баталгааг дараахь хэлбэрээр гаргана:

11.3.1. уригч нь тухайн гадаадын иргэнийг оршин суух зөвшөөрлийн болон визийн хугацаанд нь буцаахыг баталсан өргөдөл, албан бичиг;

11.3.2. мөнгөн хэлбэр (дансны хуулга, банкны хадгаламжийн дэвтэр, цалингийн тодорхойлолт, тэтгэврийн дэвтэр гэх мэт).

11.4. Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэн энэ журмын 11.3.2-т заасны дагуу баталгаа гаргах бол бичиг баримтын эх хувийг хуулбарын хамт авчирна.

11.5. Энэ журмын 11.3.2-т заасан баталгааны хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байх бөгөөд энэ нь нэг гадаадын иргэнд хамаарна.

Арванхоёр. Оршин суух зөвшөөрлийг хянан
шийдвэрлэх ажиллагаа

12.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1-д заасны дагуу гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь оршин суух зөвшөөрөл олгох болон зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэнэ:

12.1.1. энэ журмын 5.1.1, 5.1.3, 6.1, 10.1.1-10.1.4-т заасан гадаадын иргэний Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг 60 хоногийн дотор, уг зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг 30 хоногийн дотор;

12.1.2. энэ журмын 5.1.2-т заасан гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг 30 хоногийн дотор;

12.1.3. энэ журмын 5.1.4, 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор.

12.2. Гадаадын иргэнд хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзсан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ тухай хүсэлт гаргагчид шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэж, 10 хоногийн дотор тус улсаас гарахыг сануулна.

12.3. Гадаадын иргэний хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ тухай хүсэлт гаргагчид шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэж, 10 хоногийн дотор тус улсаас гарахыг сануулан, оршин суух үнэмлэхийг хураан авч, хүчингүй болгоно.

12.4. Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах, эсхүл хүчингүй болгоно:

12.4.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3, 28.4.1-д заасан үндэслэл байвал;

12.4.2. худал мэдүүлэг өгсөн;

12.4.3. тухайн гадаадын иргэнийг уригч байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;

12.4.4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн биеэр ирээгүй.

12.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь түр ирэгчийн Монгол Улсад байх хугацаа дуусмагц түүнийг түр ирэгчийн бүртгэлээс хасна.

12.6. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсаас бүрмөсөн гарах, оршин суух зөвшөөрлийн хугацаанд буцаж ирэхгүй тохиолдолд гэр бүлийн гишүүний хамт гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оршин суух үнэмлэхээ хураалган, оршин суух бүртгэлээс хасалт хийлгэнэ.

12.7. Түр ирэгчийн болон оршин суух бүртгэлээс хасалт хийхдээ гадаадын иргэний паспортдад “хасав” дардас дарж Монгол Улсаас гарах сүүлийн хугацааг зааж өгнө. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж улсын хилээр гарна.

12.8. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь уригч байгууллагын албан бичгийг үндэслэн түр ирэгчийн болон оршин суух бүртгэлээс хасалт хийнэ.

12.9. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусах өдрөөс хойш 10 хоногоос илүүгүй хугацаагаар хасалтыг хийж болно.

12.10. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлснээс хойш түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх үйлчилгээг ажлын 8 цагт, Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох үйлчилгээг ажлын 5 өдөрт, яаралтай үйлчилгээг ажлын 3 өдөрт багтаан гүйцэтгэнэ.

12.11. Албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн дугаарыг тухайн гадаадын иргэний визэнд бичиж тэмдэглэнэ.

Арвангурав. Бусад

13.1. Гадаадын иргэний паспортын хүчинтэй хугацаа оршин суух зөвшөөрөл олгоход нэг жил, сунгахад 6 сараас доошгүй хугацаатай байх бөгөөд паспорт гэмтэлгүй байна.

13.2. Монгол Улсад оршин суух хүсэлт гаргагч нь холбогдох бичиг баримтыг монгол хэл дээр бүрдүүлнэ. Гадаад хэлээр үйлдсэн бичиг баримтыг монгол хэлээр орчуулсан байна.

13.3. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө Монгол Улсад орж ирсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах боломжгүй болсон тохиолдолд энэ журмын 2.1-д заасны дагуу бүртгүүлж, 14 хоногийн дотор уг зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

13.4. Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааны нийлбэр тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд оршин суух зөвшөөрөл авна.

13.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад оршин суух зөвшөөрөл хүссэн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд татгалзсан, эсхүл түр ирэгчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шалтгааныг тайлбарлах үүрэг хүлээхгүй.

13.6. Гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэхийг дор дурдсаны дагуу кодлоно:

13.6.1. гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний оршин суух үнэмлэхийг-“А-1”;

13.6.2. төрийн байгууллагын урилгаар ирсэн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг -“А-2”;

13.6.3. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“GB-1”;

13.6.4. Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхдийн оршин суух үнэмлэхийг-“GB-2”;

13.6.5. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн болон хувийн бусад зорилгоор оршин суух гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхдийн оршин суух үнэмлэхийг- “GB-3”;

13.6.6. хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч, мэргэжил дээшлүүлэгч гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхдийн оршин суух үнэмлэхийг- “GB-4”;

13.6.7. Монгол Улсад цагаачлах гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг -“TS”;

13.6.8. хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“HG”;

13.6.9. хөрөнгө оруулах гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“Т”;

13.6.10. суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“S”;

13.6.11. Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг- “Н-1”;

13.6.12. Монгол Улсын иргэнээс төрсөн 16-гаас дээш насны гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“Н-2”;

13.6.13. Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан, гаргах боломжтой гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“Н-3”;

13.6.14. хууль хяналтын байгууллагаас гадаадын иргэнд холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл Монгол Улсад зайлшгүй байх шаардлагатай гэж үзсэн гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг-“Н-4”;

13.6.15. бусад хувийн зорилгоор оршин суух гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг -“Н-5”;

13.6.16. шашны байгууллагад ажиллах гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг -“SH”;

13.6.17. төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагад ажиллах гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг -“O”.

---oOo---